

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг баталсан бөгөөд тус өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулж "Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно." гэж заасан. Ийнхүү Улсын Их Хурлын 126 гишүүн бүхий Улсын Их Хурлыг сонгох сонгууль 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр орон даяар явагдаж, сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлээд байна.

Улсын Их Хурлаас 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг 2024-2028 онд бүрэн эрхээ хэрэгжүүлэх Улсын Их Хурал үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д зааснаар Улсын Их Хурал "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах" асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэдэг.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтад "Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах"-аар, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт "Улсын Их Хурал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар улсын төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй уялдуулан хэлэлцэнэ" гэж тус тус заасан хэдий ч энэ онд Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жил тохиосон учраас Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр завсарлуулж, дээр дурдсан хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуулиар тусгайлан заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж амжаагүй байна.

Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жил хэлэлцэн батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан асуудал буюу нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг баталж байсан хугацааны талаар лавлагаа гаргаж үзвэл 2015 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Засгийн газраас 2016 оны 06 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр хэлэлцэн баталж байсан байна. Мөн 2019 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Засгийн газраас 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдөр хэлэлцэн баталсан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт "Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно." гэж заасны дагуу 2020-2024 онд бүрэн эрхээ хэрэгжүүлсэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагчид нь буцаасан байна.

Иймээс хуульд хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь тусгайлан заасан зарим асуудлыг Улсын Их Хурлын ээлжит сонгууль явагдах жилд өмнөх Улсын Их Хурал хэлэлцэн

шийдвэрлэж амжаагүй тохиолдолд шинээр бүрдэж, бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд Хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуульд тусгайлан заасан асуудлыг Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жилийн хаврын чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол шинээр бүрдсэн Улсын Их Хурал тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох зохицуулалтыг нэмэхээр тусгалаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалтад "Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачлах ба бусад хуулийн төслийг өргөн мэдүүлэх, Улсын Их Хурлаар хэлэлцэх, батлахдаа дагалдах хэлбэрээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийг өөрчлөхийг хориглоно" гэж заасныг үндэслэн хуулийн төслийг боловсруулсан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ